

**Засгийн газраас баталсан”Бөөний худалдааны сүлжээ”
хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн
хяналт-шинжилгээ,үнэлгээний тайлан**

2009 оны жилийн эцсийн байдлаар

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1	Хөтөлбөрийг баталсан Засгийн газрын тогтоолын дугаар, огноо	Засгийн газрын тогтоол, 2001.10.01, № 219, Хөтөлбөрийг үргэлжлүүлэх тухай. 2005.12.21, №249, 2008.5.07, №169
2	Хөтөлбөрийн зорилго	Хүн амыг чанартай хүнс, өргөн хэрэглээний бараагаар, үйлдвэрлэлийг түүхий эдээр тасралтгүй хангах, бараа, түүхий эдийн бэлтгэл, нийлүүлэлтийн зохистой тогтолцоог бий болгох, бараа, түүхий эдийн хадгалалт, тээвэрлэлтийг оновчтой болгох замаар зах зээлийн бодит үнийн түвшинг бүрдүүлж хот, хөдөөгийн хоорондох үнийн зөрүүг багасгахад оршино.
Хөтөлбөрийн зорилтууд /Үе шатны хугацаатай нь авч үзэх	2001-2002 он	<p>1.Бөөний худалдааны сүлжээний эрх зүйн орчинг бүрдүүлэх, хууль тогтоомж, журам, стандарт, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийг боловсруулах, шинэчлэн батлуулах арга хэмжээ авна.</p> <p>2.Бөөний худалдааны мэдээллийн сан, сүлжээ байгуулах төсөл шалгаруулан дүгнэх,сүлжээг дэмжих төвийн үүрэг гүйцэтгэх аж ахуйн нэгжийг шалгаруулж, ажлыг нь эхлүүлэх.</p> <p>3.Улаанбаатарт бараа, түүхий эдийн бирж, барааны төрөлжсөн агуулах байгуулах судалгаа явуулах, төсөл шалгаруулах.</p> <p>4. 2001 онд Баянхонгор, Хэнтий, Орхон, 2002 онд Ховд, Дархан-Уул, Завхан, Өвөрхангай/Хархорин/, Дорнод аймагт бирж, бөөний худалдааны төрөлжсөн төв, агуулах байгуулах судалгаа хийх, байгуулах ажлыг зохион байгуулах.</p> <p>5.Энэ ажлыг нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргатай хамтран зохион байгуулах.</p>
	2003 он	<p>1. Бараа, түүхий эдийн бирж, бөөний худалдааны төвийг бусад аймгуудад байгуулах.</p> <p>2.Бөөний худалдааны мэдээллийн сүлжээний програм, технологийг зүгшрүүлж дуусгах.</p> <p>3.Бараа, түүхий эдийн экспортын мэдээлэл, сурталчилгааг олон улсын мэдээллийн сүлжээнд гаргах.</p> <p>4.Электрон худалдааны технологийг аймаг, бүсийн төвүүд, УБ хотын хооронд болон УБ-т нэвтрүүлэх.</p>
	2004 он	Бөөний худалдааны сүлжээ бүрэн ажиллаж эхлэнэ. Сүлжээг хөгжүүлэх, боловсронгуй болгох бодлого, арга хэмжээний төсөл боловсруулна.
	2005-2008 он	2001-2004 онд хэрэгжүүлсэн арга хэмжээг үргэлжлүүлэн үр дүнг дээшлүүлж, Баян-Өлгий, Өвөрхангай, Сэлэнгэ, Булган, Дундговь, Дархан-Уул аймагт “Бөөний худалдааны сүлжээ” байгуулж, түүхий эд бэлтгэлийг биржийн тогтолцоонд шилжүүлж, энэ ажилдаж ахуйн нэгжүүдийг оролцуулах арга хэмжээг хэрэгжүүлж дуусгах.

		2008-2011 он	2001-2004 онд хэрэгжүүлсэн арга хэмжээг үргэлжлүүлэн үр дүнг дээшлүүлж, Төв, Дундговь, Дархан-Уул аймагт “Бөөний худалдааны сүлжээ” байгуулж, түүхий эд бэлтгэлийг биржийн тогтолцоонд шилжүүлж, энэ ажилдаж ахуйн нэгжүүдийг оролцуулах арга хэмжээг хэрэгжүүлж дуусгах.							
4	Зардал /сая төг/	Төсөв /шаардагдах нийт зардал/	6460.0 сая төг, үүнээс 4460.0 сая төг/ төсвийн эргэж төлөгдөх хүүгүй зээл/, 2000.0 сая төг/хандивлагч орнуудын зээл, тусламж/, зээлийн эргэн төлөлтөөс тус тус санхүүжүүлнэ.							
		Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	2002 онд 1500.0 сая төг-ийн зээл олгож, эргэн төлөлтөөс нь 1660.0 сая төг-ийн зээл олгож нийт 3360.0 сая төг-ийн зээл олгожээ. Хөтөлбөр хэрэгжүүлэгч компаниуд 14.5 тэрбум төг-ийг төсөл хэрэгжүүлэхэд нэмж оруулжээ.							
5	Хүлээгдэж буй үр дүн		<p>1.Худалдаа, түүхий эд бэлтгэлийн тогтолцоо бий болно.</p> <p>2.Эрэлт, нийлүүлэлтэд тулгуурласан зах зээлийн бодит үнэ бүрэлдэн тогтоно.</p> <p>3.Зах зээлийн зарчимд тулгуурласан түүхий эд бэлтгэлийн нэгдсэн тогтолцоо бүрдэнэ.</p> <p>4.Бүсийн төв, аймаг, сумдад барааны хангалт, түүхий эд бэлтгэл, тээвэрлэлтийн оновчтой, үр ашигтай, байнгын тогтолцоо бий болно.</p> <p>5. Аймаг, хот, сум, дүүргийг хамарсан бараа, түүхий эдийн худалдааны мэдээллийн сүлжээ байгуулагдана.Электрон худалдааны сүлжээ бүрэлдэж, гадаад орнуудтай электрон сүлжээгээр худалдаа хийх нөхцөл бий болно.</p> <p>6.Хүн амын амьжиргааны түвшин дээшилнэ.</p>							
5	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	Биелэлтийн хувь	Дүн	100	90	70	50	30	10	0
		Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтын тоо	12	2	-	4	2	3	1	
6	Шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл		Төлөвлөсөн			Гүйцэтгэл				Хувь
	Шалгуур үзүүлэлт тус бүрээр	1.Худалдааны ту-хай хууль, дагалдах хуулиудын төслийг УИХ-д өргөн барих	2002 онд УИХ-д өргөн барих			2008 онд Худалдааны зохицуулал-тын тухай”, “Бараа, түүхий эдийн биржийн хууль”-ийн төслийг боловсруулсан.				50.0
		2.Бөөний худалдаа-ны сүлжээний стандарт, техникийн нөхцлүүдийг батлуулах.	2001-2002 онд боловсруулж батлуулсан байна.			МАН-н түүхий эдийн, өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэ-хүүний 52 стандарт, хүнс, бараа, түүхий эдийн 3 бүлэг агуулахын стандарт, “Худалдаа, худалдаа-ны газрын үйлчилгээ” MNS5021:2007 стандартыг батлуулжээ.				90.0

	3.Бөөний худалдаа-ны мэдээллийн сан, сүлжээ байгуулах төсөл боловсруулах	2001 онд боловсруулна.	Бөөний худалдаа, боловсруулах үйлдвэр, тээвэр зууч, гаалийн баталгаат агуулахын аж ахуйнуу-дын тухай, гол нэрийн барааны үнийн мэдээлэл агуулсан www.salesnetwork.mn вэб хуудас ажилд оруулсан. /2003.11 сар/ , Мэдээллийн сүлжээ төслөөр цахим худалдаа хийх боломжтой www.mongoltrade.mn вэб хуудас ажиллуулж эхэлсэн. УБ, орон нутгийн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн зах зээлийн үнэ, эрэлт, хэрэгцээний мэдээлэл агуулж байна.	100.0
	4.Мэдээллийн сүл-жээг дэмжих төвийн ажлыг эрхлэх аж ахуйн нэгжийг шал-гаруулж, ажлыг нь эхлүүлэх.	2001 онд ажлыг эхлүүлнэ.	Мэдээллийн сүлжээг дэмжих төвийг байгуулаагүй, хүч бололцоондоо тулгуурлан www.mongoltrade.mn вэб хуудсыг ажиллуулж байна.	30.0
	5.УБ-т бараа, түүхий эдийн төрөлжсөн болон холимог агуулах, бөөний худалдааны төв, бирж байгуулах судалгаа хийж, байршлыг тогтоож, эрхлэх аж ахуйн нэгжүүдийг шалгаруулах, ши-нээр байгуулахад дэмжлэг үзүүлэх.	2001-2002 он, 2006-2008 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.	Нийслэл болон төвлөрсөн хот сууринд байсан мал, малын түүхий эдийн төрөлжсөн захуудыг хотын гадна байршуулсан.УБ-ын 3 дүү-рэгт олон улсын стандартад нийцсэн бөөний худалдааны төв барих байршил, газрын хэмжээг батлуулж, зураг төслийг хийж дуусгасан.Хөрөнгө оруулагчдыг олох судалгаа хийж байна.	70.0

	6.Аймгуудад бирж, бөөний худалдааны төв байгуулах.	2001 онд Баянхон-гор, Хэнтий, Ор-хон, 2002 онд Ховд, Завхан, Дорнод, Дархан-Уул, Өвөрхангай/ Хар-хорин/, 2003 онд бусад аймгуудад, 2005-2008 онд Баян-Өлгий, Өвөрхангай, Сэлэнгэ, Булган, Дундговь, Төв, Дархан-Уул, 2008-2011 онд Төв, Дархан-Уул	2002 оноос Орхон, Хэнтий, Баянхонгор, 2003 оноос Архангай, Завхан, Өмнөговь, Дорнод, 2004 оноос Ховд, Увс, Говь-Алтай, Хөвсгөл, 2005 оноос Дорноговь, Говьсүмбэр, Хөвсгөл, 2006 оноос Баян-Өлгий, 2007 оноос Өвөрхангай, Сэлэнгэ, Булган зэрэг 18 аймагт хөтөлбөр хэрэгжиж 116 сумыг хамарч байна. Дундговь аймагт төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулаад байгаа.	86,0
	7. Вексель, өрийн бичиг гаргах, түүнийг мөнгөжүүлэх талаар чиглэл гаргаж Монгол банкнаас хийх вексель өрийн бичгийн туршилтад зарим бараа, түүхийг эд бэлтгэн нийлүүлэгчдийг хамруулах	Вексель, өрийн бичгийг 2001 оны 9 дүгээр сард гаргах	2004 онд хөтөлбөрт оролцогчдын сургалт-семинари хийсэн. Бирж, бөөний худалдааны төв, агуулах дахь барааны үлдэгдэл бага байгаа тул вексель өрийн бичиг гаргах шаардлагагүй болжээ.	-
	8.Бөөний худалдааны мэдээллийн сүл-жээ байгуулах төслийг хандивлагч орнуудын зээлд хамруулах арга хэмжээ авах	2001 оны 6 дугаар сард хэрэгжүүлэх	Хандивлагчдын зээлд хамрагдаагүй ч санхүүжилтийг шийдвэрлэж 2005 оны 11 дүгээр сард www.mongoltrade.mn вэб хуудсыг ажиллуулж эхэлсэн.	100.0

		9.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ТББ-уудтай чиглэл, төлөвлөгөө гарган хамтран ажиллах	Чиглэл, төлөвлөгөөг 2001 оны 12 дугаар сард гаргах.	Хамтран ажиллах чиглэл, төлөв-лөгөө гаргаагүй. “Хөдөөгийн өөртөө туслах нэгжийг дэмжих төсөл”, Монголын эд хэрэглэгч-дийн хоршоодын төв холбоотой хамтран Дорноговь, Баянхонгор, Ховд аймагт бүсчилсэн сургалт зохиосон. “Иод дутлын эмгэгтэй тэмцэх хөтөлбөр”-тэй хамтран ажиллаж байна. “Говийн бүсийн эдийн засгийн санаачилга” хөтөлбөртэй хамтран орон нутгийн түүхий эдийн үнийг мэдээлдэг “Зах зээл ажиглагч” нэвтрүүлгийг монголын радиогоор явуулж байна.	50.0
7	Хөтөлбөрийн гол үйл ажиллагаа, гарц			Бөөний худалдааны сүлжээний хууль, эрх зүйн орчин бүрдүүлэх, аймгуудад бөөний худалдааны төвүүдийг бий болгох, мэдээллийн сүлжээ байгуулах, оролцогч компаниудад зээл олгох, эргэн төлүүлэх үйл ажиллагааг явуулсан. “Худалдааны зохицуулалтын тухай”, “Бараа, түүхий эдийн биржийн хууль”-ийн төслийг боловсруулсан. Бүтээгдэхүүний 52 стандарт, агуулахын 3 бүлэг стандарт, “Худалдаа, худалдааны газрын үйлчилгээ” MNS5021:2007 стандартыг батлуулжээ. Бөөний худалааны төв 18 аймагт байгуулж 116 сумыг хамруулсан. www.salesnetwork.mn , www.mongoltrade.mn вэб хуудсуудыг бий болгосон. Нийт 3.36 тэрбум төгрөгийн зээл олгож, 2.4 тэрбум төгрөгийн зээлийг эргэн төлүүлсэн ба 579.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл байна. 2009 онд шинээр зээл олгоогүй.	
8	Дүгнэлт /хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, үр ашиг, үр өгөөж/			Хөтөлбөрийн хэрэгжилт 85 хувь байна. Хөтөлбөрийн үр дүнд гол нэрийн өргөн хэрэглээний барааны нэр төрөл, хангамж сайжирсан, үнийн зөрүү 20-30 хувиас 3-5 хувь болж буурсан, 60 гаруй ажлын байр бий болсон, худалдаа, үйлчилгээнд дэвшилтэд, шинэ хэлбэрүүд нэвтэрсэн, бизнес эрхлэгчдийг зах зээлийн мэдээллээр хангах суурь тавигдсанзэрэг бодитой үр дүн гарсан. Хөтөлбөрт аймгуудын 80 гаруй хувь хамрагдсан байх боловч сумдын 30 гаруй хувь хамрагдсан байгаа нь хангалтгүй байна. Өргөн хэрэглээний барааны хангамж, нийлүүлэлт сайжирсан боловч, бөөний худалдааны сүлжээгээр хийгдэх түүхий эдийн худалдаа гэсэн нөгөө тал нь үндсэндээ орхигдож байна.	
9	Хүлээгдэж буй үр дүндээ хүрээгүй бол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлс, гарсан гажуудал			Хөтөлбөрийг 2001-2004 онд хэрэгжүүлж дуусгахаар анх төлөвлөсөн боловч хугацааг Засгийн газрын шийдвэрээр 2 удаа сунгаж 2011 он болгоод байна. Хөтөлбөртэй холбогдох хууль эрх зүйн орчинг одоо болтол бүрдүүлээгүй, шаардагдах санхүүжилтын эх үүсвэр дутагдалтай /4.5 тэрбум төг төлөвлөөд 1.5 тэрбум төг-ийн санхүүжилт өгсөн/ зэргээс болж хэрэгжилт удаан байна.	
10	Эдгээрээс гарах арга зам			1.Хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх арга хэмжээг шуурхайлах 2.Бөөний худалдааны төвүүдийн хамран үйлчлэх сумдын	

		<p>тоог нэмэгдүүлэх</p> <p>3.Сүлжээгээр явуулах түүхий эд бэлтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх</p> <p>4. Хөтөлбөрийн хүрээнд байгуулсан бөөний худалдааны төвүүд, мэдээллийн сүлжээг бүрэн дүүрэн ашиглах</p>
11	Хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцогч талуудын талаархи үнэлгээ	<p>СЯ, ХХААХҮЯ, гүйцэтгэгч компаниудын хооронд гурвалсан гэрээтэй ажиллаж, түүнийг дүгнэж ирсэн байна. Гэрээний үүргийн дүнгээр 11 аймагт хангалттай сайн, 3 аймагт хангалтгүй , 4 аймагт хөтөлбөр хэрэгжилтийн шатандаа байна. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд төв, орон нутгийн 55 аж ахуйн нэгж оролцож байна.</p>
12	Хөтөлбөрийн талаарх яамны санал / өөрчлөн сайжруулах болон бодлогод үзүүлж буй хөтөлбөрийн дэмжлэгийг нэмэгдүүлэх талаар гэх мэт/	<p>Хөтөлбөрт хамаарах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд УИХ, Засгийн газар дэмжлэг үзүүлж хэлэлцэж батлахад шуурхай хандмаар байна. Үлдэж буй 3 аймагт бөөний худалдааны төв байгуулах ажлыг зээлийн эргэн төлөлтийн хүрээнд 2010 онд багтаан гүйцэтгэх, хамрагдах сумдын нэмэгдүүлэх, бий сүлжээг бэхжүүлэн тогтворжуулах арга хэмжээ авах шаардлагатай</p>
13	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн байгууллагуудын оролцооны талаархи санал/дэд хөтөлбөртэй байх, тухайн аймаг заавал хэрэгжүүлэх шаардлага байгаа эсэхийг тодорхойлох гэх мэт/	<p>Хөтөлбөрийн тайлангаас харахад орон нутгийн төр захиргааны байгууллагын оролцоо хангалтгүй, бүх асуудлыг төвөөс шийдвэрлэх гэсэн хандлага байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төр , захиргааны байгууллагын оролцоог хангах арга хэмжээ авах хэрэгтэй. Хөтөлбөрийн өмнөх жилүүдэд гарсан үр дүнг орон нутгийн холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөх.</p>

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Т.ГАНТУЛГА